

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭС, ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### THE BASIS FOR COUNTER-TERRORISM OPERATIONS OF THE POLICE: AN ANALYSIS



#### П.ЛУВСАНДОРЖ

Хууль сахиулахын их сургуулийн магистрант, Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын Төлөөлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

#### LUVSANDORJ P.

(M.L. Student & Police Lt. Colonel) Head of the Planning and Management Unit of the Sukhbaatar Aimag Police Station

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэлд терроризмын тухай ойлголт, мөн чанар, учруулах хор аюулын хэлбэр, терроризмтой тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, цагдаагийн алба хаагчийн чадавх, түүнийг сайжруулахтай холбоотой асуудлын талаар товч авч үзсэн болно.

**Abstract:** This article concisely examines the understanding and nature of terrorism, the forms of potential danger, the legal regulations of anti-terrorist activities of the police and issues of improving the capacity of police officers.

**Түлхүүр үгс:** терроризм, эрх зүйн зохицуулалт, цагдаагийн алба хаагч, зохицуулах зөвлөл, сөрөг тусгай ажиллагаа

**Keywords:** terrorism, legal regulations, police officer, coordinating council, special operations

#### Үндсэн хэсэг

XXI зуунд дэлхийн улс орнууд олон улсын терроризмын сүлжээнд автагдаж, түүний аюул занал хаана, хэдийд ч, ямар ч хэлбэрээр илэрч болох эрсдэл бий болох нөхцөл байдал улам бүр нэмэгдсээр байна.

Терроризм түүхэн улбаатай, бүр манай он тооллын I зууны Зилотууд болон Сисариас эхлээд XVIII зууны сүүл үеийн Францын хувьсгал, XIX зууны сүүл үеийн анархистууд, XX зууны улс төрийн хэт даврагч бүлгийнхний үйл ажиллагаа тухайлбал, Оросын ардын тэмцэл, Алжирын үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, Ирландын улаан арми, Италийн улаан бригадынхан, Колумбын Хувьсгалт зэвсэгт хүчнийхэн зэргээр дамжин илэрсээр өнөө үетэй холбогдож байна. □

Хүн төрөлхтөнийг хэрэн сүлжиж, айдаст автуулаад байгаад терроризмын

эсрэг тэмцэлд дэлхийн улс орнууд хамтын хүчин чармайлтаар тэмцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл их гүрэн, жижиг, буурай орон гэж ялгалгүй терроризмын болзошгүй аюулаас сэрэмжлэх, урьдчилан сэргийлэх, гарч болох эрсдлийг бууруулах арга хэмжээг улс орон, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь дэлхийн улс орон бүрийн үүрэг болоод байна.

Терроризмын эсрэг тэмцэлд нийгмийн хэв журмыг хангах болон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хүчтэй тэмцлийг зохион байгуулж, үүнд иргэний байгууллагуудыг оролцуулж чадсан улс үндэстэн ихээхэн амжилт олсоор байна.<sup>1</sup>

Терроризм нь тухайн улс орны хил хязгаар, том жижиг, баян хоосон, хөгжил дэвшил, яс үндэс, цэргийн хүчин чадавхиас үл хамааран хаана ч бий болзошгүйгээрээ хамгийн их аюултайд тооцогдож байна.

Сүүлийн жилүүдэд зарим улс оронд үндэстний цөөнх болсон угсаатан, ястнууд тусгаар тогтнохын төлөө хөдөлгөөн идэвхижүүлж буй хийгээд зарим шашны зүтгэлтнүүд өөрийн шашныхаа “үнэт” гэж үзэх зүйлсийг үндэстэн дамнуулан тархаан түгээх хандлага, оролдлого илт хийх болсон нь улам бүр хурдаа авч буй даяаршлын үр дүн, үйлдэл гэж үзэх үндэстэй байна.

Тэд өөрсдийн хөдөлгөөн, тэмцэлдээ террорист ажиллагаа, террорист үйлдлийг өргөн хэрэглэх болсноор олон улсын терроризмд хил хязгаар гэж байхгүй болж, ажиллагаа нь даяаршлыг шинжийг агуулах болжээ.<sup>2</sup>

<sup>1</sup> Ц. Дашзэвэг., Д. Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. УБ., 2004. 29 дэх тал.

<sup>2</sup> Ч.Баатар., Ч.Алтангэрэл. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхноо хамгаалах нь. УБ.,



Хууль сахиулахуй

Терроризм нь зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөсөн, хөрөнгө, санхүүгээр дүлдүйдсэн, зэвсэг, хөнөөх хэрэгслийн хүчинд тулгуурласан экстремист<sup>3</sup>, салан тусгаарлагч үзэлтэй харгис цөөн хүний хүрээллийн дотор маш нууц бэлтгэгдэж, шуурхай явуулдаг үндэстэн дамжсан эрүүгийн онц ноцтой гэмт хэргийн шинжтэй дэндүү хэрцгий хүчирхийлэл болоод байна.

Терроризмын зорилго нь улс төр, нийгмийн байгууллын тогтолцоог өөрчлөх, төрийн байгууллын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх гэсэн үндсэндээ улс төрийн агуулгатай байна.<sup>4</sup>

Терроризм нь хаана хяналт шалгалт сул, сонор сэрэмжгүй, назгай байдал ноёрхож, хүн ард нь түүний эсрэг тэмцэх бэлтгэлгүй байна, тэнд орон зайгаа олон цэцэглэн хөгжиж, нутагшиж байдгийг амьдралаас харж болохоор байна.

Айлган сүрдүүлэх, алан хядах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж буй хүчирхийллийн нэг хэлбэр болох терроризм нь ардчилсан нийгмийн улс төр, эдийн засаг, эрх зүй, оюун санааны амьдралд дарамт үзүүлж, өөрийн хүсэл зорилгыг бусдад тулган хүлээлгэхэд чиглэгдсэнээрээ нийт хүн төрөлхтөний аюулт дайсан болж байна.<sup>5</sup>

Нөгөө талаараа терроризм нь нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулах зорилго бүхий сэтгэл зүйн дайралт гэж үзэж болно. Террористууд сэтгэл зүйн дайралт явуулахдаа энгийн номхон иргэдийн эсрэг харгис хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэхээр заналхийлэхийг үндсэн арга болгон ашиглаж байна.

Терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хуулийн 3.1.1-д “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа”<sup>6</sup> гэж тодорхойлсон байдаг байна.

Энэ тодорхойлолтыг доктор, профессор Ш.Паламдорж АНУ, ОХУ, Их Британи

2006.3 дахь тал.

<sup>3</sup> Ц. Дашзэвэг, Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ., 2004. 19 дэх тал

<sup>4</sup> Хэт даврагч гэсэн агуулгатай үг юм.

<sup>5</sup> Ц. Дашзэвэг, Д.Чагнаадорж. олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ., 2004. 20 дахь тал

<sup>6</sup> Терроризмын эсрэг. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ. 2003. 4 дэхь тал

улсууд болон олон улсын судлаачдын тодорхойлолтуудтай харьцуулан үзэхэд нийгэмд бүхэлд нь эсхүл түүний тодорхой бүлэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгын хувьд төсөөтэй боловч төдийлөн оновчтой бус байна хэмээсэн байдаг.

Дэлхийн улс орны олон эрдэмтэн судлаачид “Терроризм” хэмээх энэхүү үгийг янз бүрээр ойлгож, тайлбар хийж, үзэл бодлоо илэрхийлсээр байгаа боловч тодорхой нэгдсэн нэг тодорхойлолтыг одоо хүртэл өгч чадаагүй байна.

Терроризм нь даяаршиж байгаа нийгмийн аюулт үзэгдлийн нэг болж байгаа нь дэлхийн улс орнуудад болж байгаа террорист халдлагуудын тоо, давтамж, учруулж буй хохирлын хэмжээ харуулж байна.

Өнөөдөр терроризмтой хийх тэмцэлд ердийн тэсрэх бодисоос эхлэн шинжлэх ухааны, технологийн сүүлийн үеийн шинэ шинэ ололтуудыг ашиглах явдал нэмэгдэх хандлагатай байна.

Үүний нэг нь хүний далд ухамсар, сэтгэцэд зайнаас нөлөөлөх арга технологи буюу психотроны хэмээх шинэ зэвсэг бөгөөд шинэ зуунд хамгийн аюултай зэвсэг хэмээн нэрлэгдэж байна.

Түүнчлэн террористууд айлгах, сүрдүүлэх, хуурах, итгүүлэх, дарамтлах, барьцаалах гэх мэт хүний оюун санаа, сэтгэл зүйд нөлөөлөх замаар зэвсэгт тэмцлийн бүхий л аргуудыг өргөнөөр хэрэглэж байгаа нь нийгмийн аюулт үзэгдлийн хор аюулын хэр хэмжээг улам нэмэгдүүлэх хандлагатайг харуулж байна.

Хэдийгээр Монгол Улс дэлхийн 2 том хүчирхэг гүрний дунд оршдог, терроризмын аюул нүүрлээгүй дэлхийн цөөн улсуудын нэг боловч өнөөдөр хоёр хөрш оронд маань террорист халдлага удаа дараа үйлдэгдэж, тэдэнтэй тэмцэл улам бүр нэмэгдэх хандлагатай болсоор байна.

Бид өнөөдөр террорист халдлага, түүний учруулсан хор аюулын талаархи мэдээллийг Ойрхи Дорнод, Өмнөд Азид болж буй үйл явдлаар төсөөлөн ойлгодог байсан бол өнөөдөр хөгжил дэвшил бүхий Баруун Европ, АНУ, манай хойд, урд хөршид гарч байгаа нь терроризм өөрөө даяарших хэлбэр лүү хэдийнээ шилжин орсонтой холбоотой юм

Бүх төрлийн терроризмын үндсэн зарчим нь нэгдмэл, хүчирхийлэлд суурилсан, ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, улс төрийн үзэл бодол, бодлого мөн бөгөөд иргэд, олон нийтийг алах, алахаар заналхийлэх,

айлган сүрдүүлэх зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зорилгодоо хүрэх гол хэрэгсэл болгон сонгосонд оршиж байна.

Бид юуны өмнө аливаа террорист халдлага аюул заналыг зэргэлдээ орнуудад болж буй үйл явдал, тэдний гадаад шинж төрх байдал, олон улс орныг хамрах хүрээ, далайц зэрэгт дүгнэлт хийж, улс орны хил хязгаарыг нэвтрэн орж ирж болзошгүй нөхцөлд хариу арга хэмжээг цаг алдалгүй авахад бэлэн байж, дотооддоо нэн сонор сэрэмжтэй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанаас гадна иргэд, олон нийт өндөр мэдрэмжтэй, сонор сэрэмжтэй байхыг цаг үе зүй ёсоор сануулж байна.

Түүнчлэн хөрш орнуудад болж буй террорист халдлагатай холбоотой гарч буй үйл явдлыг байнга ажиглаж, холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч байх шаардлагатай болж байна.

Терроризмтой тэмцэх, терроризмын эсрэг дэлхийн улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр олон улсын нийтлэг эрх зүйн 19 баримт бичиг байдгаас өнөөгийн байдлаар 13-д нь манай улс 1971 оноос хойш нэгдэн орсон нь терроризмтой тэмцэх асуудлыг төрийн бодлогын хэмжээнд олон жилийн турш авч хэрэгжүүлж ирсний тод илрэл юм.<sup>7</sup>

Нөгөө талаараа Монгол Улс Терроризмын эсрэг олон улсын гэрээ, конвенц, протоколд нэгдэн орсноор дэлхийн улс орны өмнө олон талт үүрэг хүлээж байгаа бөгөөд дээрхи олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг хэрэгжүүлэхэд олон улсын болон бусад орны байгууллагатай хамтран ажиллах хэлбэрийг зөв оновчтой, үр дүнтэй сонгож ажиллах шаардлагатай болж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр терроризмтой тэмцэх тухай хуулийг батлан гаргаснаар терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах үндэсний эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн төдийгүй 2013-2014 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар терроризмтой тэмцэхэд чиглэсэн эрх зүйн тогтолцоогоо бэхжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар нь терроризмоос сэргийлэх ажлыг удирдах үндсэн субъект бөгөөд хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргийг Терроризмтой тэмцэх ажиллагааг

<sup>7</sup> Төрийн мэдээлэл. УБ., 2004. №19

зохицуулах зөвлөл хүлээдэг.

Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.3 “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль<sup>8</sup>-д заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмоос сэргийлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна<sup>9</sup>” гэж зохицуулж өгсөн билээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 12 дугаар сарын 147 тоот захирамжаар Терроризмоос сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг Тагнуулын ерөнхий газрын дарга ахлан 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Терроризмын аюулыг гарсан хойно нь тэмцэж, үйлдсэн этгээдийг илрүүлэхдээ бус, харин терроризмын үндсэн суурь нөхцөл бүрэлдэн тогтохоос өмнө, гарч болох бүхий л шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Харин цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх үйл ажиллагааны арга, хэлбэр, хамрах хүрээнээс хамаарч дараах хууль тогтоомжуудыг үйл ажиллагааны эрх зүйн үндсээ болгож ашиглана. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хууль
  - Терроризмтой тэмцэх тухай хууль
  - Эрүүгийн байцаан шийтгэх хууль
  - Галт зэвсгийн тухай хууль
  - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
  - Онц байдлын тухай хууль
  - Дайн бүхий байдлын тухай хууль
  - Захиргааны хариуцлагын тухай хууль
  - Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2004 оны 25 дугаар тогтоол<sup>10</sup>
  - Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай Засгийн газрын 2001 оны 226 дугаар тогтоол<sup>11</sup>
- Дээрхи хууль тогтоомжуудын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох зарим зүйл, заалтуудаас авч үзвэл:
- **Цагдаагийн албаны тухай хууль:**
    - Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дүгээр зүйл /Олон нийтийн аюулгүй байдлыг

<sup>8</sup> Олон улсын терроризм ба аюулгүй байдал. ЭШБХ-ийн эмхтгэл. УБ., 2015. 18 дахь тал

<sup>9</sup> Төрийн мэдээлэл. 2002. №3

<sup>10</sup> Төрийн мэдээлэл. 2004. №19

<sup>11</sup> <http://www.legalinfo.mn/law/details/6691?lawid=6691>



ХУУЛЬ САХИУЛАХУЙ  
 МУНГУУЛ УЛАА  
 ХУУЛЬ ЗОХИОН  
 АЖИЛЛАГААНЫ  
 УНДГАВЧИЛГА

хангах/-ийн 11.1.3. нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах<sup>12</sup>;

• **Терроризмтой тэмцэх тухай хууль:**

- Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйл /Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллагын хүч хэрэгсэл/-ийн 10.1.1.цагдаагийн төв, орон нутгийн байгууллага

- 11.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцож байгаа салбар, нэгж, бие бүрэлдэхүүн тусгай ажиллагаа үргэлжлэх хугацаанд шуурхай штабын даргад шууд захирагдана.

- 12.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийг шуурхай штабын дарга тогтоож, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйл<sup>13</sup>, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулж болно<sup>14</sup>;

• **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль:**

- 17 дугаар зүйл /Эрх бүхий хууль сахиулах байгууллагын чиг үүрэг/-ийн 17.2.Эрх бүхий хууль сахиулах байгууллагын төлөөлөл нь энэ хуулийн 16.9-д заасны дагуу хяналт шалгалт хийх, санхүүгийн лавлагаа гаргуулж авах эрхтэй.

- 22.2.Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажиллана.<sup>15</sup>

Мөн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан терроризмоос сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл нь уг хуулийн 10.1-д заасан хүч хэрэгсэлд хамаардагын хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл гэж үзэж болно. Үүнд:

1. Улс орондоо террорист байгууллага, бүлэг үүсэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхээс сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах;

2. Иргэдэд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх;

3. Газар нутагтаа олон улсын терроризм, террорист этгээд үл нэвтрэх, үл орогнох, үл нутагших орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

<sup>12</sup> <http://www.legalinfo.mn/law/details/3766?lawid=3766>

<sup>13</sup> Төрийн мэдээлэл. 2013. №29

<sup>14</sup> УИХ-ын 2013 оны 7 сарын 5-ны өдрийн

<sup>15</sup> Төрийн мэдээлэл. 2004. №19

4. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавхи, бэлэн байдлыг хангах;

5. Иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах;

6. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;

7. Төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;

8. Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;

9. Бусад улс, тэдний хууль сахиулах байгууллага, тусгай албад, олон улсын холбогдох байгууллагатай терроризмоос сэргийлэх, террорист үйлдлээс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах.

Дээрхи терроризмоос сэргийлэх арга хэмжээний чиглэлүүдийн 2-7, 9 нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдож байгааг анхааран авч үзэх шаардлагатайг харуулж байна. Үйл ажиллагааны чиглэл тус бүрээр авч үзвэл:

- *Улс орондоо террорист байгууллага, бүлэг үүсэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхээс сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах;*

Энэ нь Засгийн газрын үйл ажиллагааны нэг хэсэг байх бөгөөд терроризмтой тэмцэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах, терроризмын шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээ төлөвлөх, террор гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгай чиг үүргийн байгууллагуудад үүрэг чиглэл өгөх, холбогдох зардал мөнгийг нь шийдэх, үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх зэрэг олон ажиллагаанууд хамаарна.

- *Иргэдэд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх;*

Энэ нь дан ганц төрийн тусгай чиг үүргийн байгууллагын үүрэг төдийгүй төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагууд ихээхэн үүрэгтэйгээр оролцоно.

Иргэдийн сэтгэлгээнд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлыг

төрийн болон төрийн бус байгууллага /Терроризмын эсрэг Монголын холбоо/ голлох үүрэгтэйгээр оролцох бөгөөд тэдэнд цагдаа, тагнуулын байгууллага дэмжлэг үзүүлж хамтарч ажиллана.

Түүнчлэн улсын болон хувийн хэвшлийн олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

- Газар нутагтаа олон улсын терроризм, террорист этгээд үл нэвтрэх, үл орогнох, үл нутагших орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

Энэ чиглэлд тагнуул, цагдаагийн байгууллага голлох үүрэгтэйгээр оролцох боловч энэ нь олон байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих боломжтой билээ.

Учир нь гаалийн байгууллага, хил хамгаалах алба, мэргэжлийн хяналтын алба, татварын байгууллага, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар, онцгой байдлын албад зэрэг олон байгууллага, албадын хамтын ажиллагаагаар үр дүн нь тодорхойлогддог онцлогтой ажил билээ.

Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл<sup>16</sup> нь эдгээр байгууллагуудын хамтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавхи, бэлэн байдлыг хангах;

Энэ чиг үүргийг Зэвсэгт хүчний 084-р ангийн тусгай томилгоот бүлэг, 150-р элитийн батальон, Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх тусгай тактикийн бүлэг, Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газрын Тусгай бэлтгэлтэй тактикийн бүлгүүд хамтран хэрэгжүүлнэ. Тэгэхдээ терроризмын эсрэг тусгай ажиллагаанд Тагнуулын газрын дэргэдэх тусгай тактикийн бүлэг голлох үүрэгтэйгээр оролцох бөгөөд бусад чиг үүргийн бүлгүүд дэмжлэг үзүүлж хамтран оролцоно.

- Иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах;

Энэ чиг үүргийг цагдаагийн байгууллага голлон гүйцэтгэх бөгөөд гудамж, талбай, олон нийтийн газарт нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх, нийтийг хамарсан арга хэмжээний үеэр олон нийтийн аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохион байгуулна.

Түүнчлэн тагнуулын байгууллага гүйцэтгэх

ажлын хүрээнд олж авсан мэдээллийн дагуу цагдаагийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулна.

- Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн захиргааны хяналтын хүрээнд галт зэвсгийн ашиглалт, хэрэглээнд хяналт тавихын зэрэгцээ тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисын тээвэрлэлтэнд зөвшөөрөл олгохын зэрэгцээ хамгаалалтыг нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хариуцан ажиллах бөгөөд уг зэвсэг, хэрэгсэл, бодисын хамгаалалтанд ажиллаж байгаа гэрээт харуул хамгаалалтын албаны үйл ажиллагаанд захиргааны хяналт тавьж ажиллана.

- Төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;

Улс орны нийгэм эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий улсын онц чухал объектуудыг Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хариуцан хамгаалалтыг зохион байгуулах, түүнчлэн соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах хэв журмын эргүүлийн үйл ажиллагааг Нийтийн хэв журам хамгаалах алба хэрэгжүүлж байна.

- Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;

Террорист халдлагад өртөх эрсдэл бүхий объектуудын судалгаа хийн, халдлага гарч болох нөхцлүүдийг арилгах, хохирлыг багасгахад чиглэгдсэн сургалт, дадлагыг төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын тусгай бэлтгэлтэй тактикийн бүлгүүд хамтран тогтмол зохион байгуулна.

#### ● Олон улсын гэрээ, конвенци:

- Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц<sup>17</sup>

- Конвенци соёрхон батлах тухай /НҮБ-ын Ерөнхий ассамблей 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр баталсан "Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай" /

- Конвенцийг соёрхон батлах

<sup>17</sup> Ерөнхий сайдын 2004 оны 12 дугаар сарын 147 тоот захирамжаар Терроризмоос сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг Тагнуулын ерөнхий газрын даргаар ахлуулан 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

<sup>16</sup> Төрийн мэдээлэл. 2013. №24

тухай /Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц/

- Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай олон улсын конвенц

Терроризмтой тэмцэх тухай хуульд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь терроризмоос сэргийлэх ажлыг удирдах үндсэн субъект бөгөөд хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргийг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлхүлээдэг.

Зохицуулах Зөвлөл нь Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.4-т заасан дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төрийн байгууллагуудын терроризмоос сэргийлэх бодлогыг уялдуулан зохицуулж байна. Үүнд:

1. Терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх.

2. Терроризмын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, Засгийн газрыг шуурхай мэдээллээр хангах, санал оруулах.

3. Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдан зохицуулах.


4. Террорист үйлдлээс сэргийлэх зорилгоор төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд үүрэг өгч, түүнийг хэрэгжилтийг хангуулах.

Манай улсад террорист халдлага, түүнтэй холбоотой гэмт хэрэг гараагүй /гарсан ч олон нийтэд мэдээлэгдээгүй/ нь түүний хор аюулын талаар мэдээлэлгүй, учрах аюулын талаар ойлголт бага байгаа, үүнд ард иргэд нь дасал болсон нь хамгийн том эрсдэлийг дагуулж байна.


Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн терроризмтой тэмцэх мэдлэг болон бэлтгэжилт ямархуу түвшинд байгааг тогтоох зорилгоор БЗД-ийн цагдаагийн I, II, III хэлтсийн 14хэсгийн байцаагч нараас судалгаа авч үзлээ.

#### Та терроризмын хор аюулын талаар хэр сайн мэдэх бэ?


■ сайн мэднэ ■ бага зэрэг ■ мэдэхгүй



#### Та терроризмтой тэмцэх тухай хуулийн 8-р зүйлд заасан "терроризмоос сэргийлэх талаар иргэний хүлээх үүрэг"-ийг мэдэх үү? уншиж, танилцаж байсан уу?



#### Та терроризмын аюул тулгарахад ямар арга хэмжээ авч ажиллахаа мэдэх үү?



#### Танд болон танай гэр бүлийн гишүүдэд терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл дамжуулах чиглэлээр хичээл сургалт, заавар, зөвлөмж өгч байсан уу?



Судалгааны дүнг авч үзвэл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын терроризмтой хийх чадавх, мэдлэгийн түвшин хангалтгүй түвшинд байна гэж үзэж болохоор байна.

Цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх чиглэлээр ямар ямар ажиллагааг явуулахыг "Терроризмтой тэмцэх тухай хууль"<sup>18</sup>-ийн 9-р зүйл /Террорист үйлдлийн сөрөг

<sup>18</sup> Төрийн мэдээлэл. 2004.№19

тусгай ажиллагаа/-ийн 9.1-д “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын болон цэргийн хамтарсан хүч хэрэгслээр тусгайлан хэрэгжүүлэх дараахь ажиллагаа хамаарна” гэж тусгайлан зааж өгсөн байна. Үүнд:

1. Террорист ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэх, түүнээс иргэн, байгууллагыг сэрэмжлүүлэх, хамгаалах;

2. Террорист үйлдэлд өртсөн иргэн, эд хөрөнгийг аврах, хамгаалах;

3. Террорист ажиллагаа, террорист үйлдэлд хүргэж буй шалтгаан нөхцөлийг арилгах;

4. Террорист үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

5. Террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;

6. Террорист ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах;

7. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бэлтгэж явуулах хууль тогтоомжид заасан бусад тусгай ажиллагаа.

Харин цагдаагийн алба хаагчид дээрхи ажиллагаануудыг хэрхэн яаж гүйцэтгэх талаар нарийвчлан тусгасан заавар, журам өнөөг хүртэл гараагүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Цагдаагийн байгууллагын хувьд зөвхөн ЦЕГ-ын харьяа Тусгай ажиллагааны газрын тусгай бэлтгэлтэй тактикийн бүлгийн алба хаагчдыг мэргэшүүлэн бэлтгэж байна.

Гэтэл нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдын хувьд терроризмтой тэмцэх чиглэлээр сургалт төдийлөн явагддаггүй, энэ чиглэлийн ойлголт харьцангуй муу байгаа нь терроризмтой тэмцэх ажиллагааг улам бүр сулруулж байна гэж үзэж болохоор байна.

Тиймээс нэн даруй дээрхи албадын цагдаагийн алба хаагчдад зориулан терроризмтой хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрхэн зохион байгуулж, гүйцэтгэх арга зүйг тусгасан гарын авлага боловсруулж, сургалт явуулах шаардлага тулгарч байна.

Үүнээс гадна терроризмын аюул, учрах хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад цагдаагийн байгууллага, тэр дундаа засаг захиргааны анхан шатны нэгж хариуцсан цагдаагийн байцаагчийн үүрэг оролцоог дутуу үнэлж болохгүй юм.

Учир нь хэсгийн байцаагч /төлөөлөгч/ нь өөрийн хариуцдаг нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэдтэйгээ хамгийн ойр дөт байж, тэдэнд хууль зүйн үйлчилгээ үзүүлж, үйлчилснийхээ хэрээр ард иргэдээсээ итгэл хүлээж, тэднээр туслалцуулж, хамтран ажилладаг, иргэдийн итгэлийг хүлээж чаддаг бөгөөд тэр хэрээр иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл олж авдаг нь терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоход ихээхэн чухал үүрэгтэйгээр оролцох боломжтой болохыг харж болох юм.

Тиймээс нэн түрүүнд хэсгийн байцаагч /төлөөлөгч/-дийг терроризмтой тэмцэх, түүний хор аюулаас урьдчилан сэргийлэх арга зүйд хурдан сургах, түүний ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага бий болоод байна.

### Дүгнэлт

Өнөөдөр аюулгүй байдлын уламжлалт ойлголт өөрчлөгдөж, хүнийг өөрийг нь зэвсэг болгон ашиглах болсон нь терроризмын үнэн мөн чанарыг харуулж байна.

Хамгийн сүүлд гэхэд ОХУ-ын Санкт-Петербург хотод 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Сенная площадь-Технологический институт гэх метроны хоёр буудлын хооронд тэсрэх бөмбөг дэлбэрч, үүний улмаас 11 хүн амь насаа алдаж, 47 хүн шархадсан байна.<sup>19</sup>

Манай улсад Терроризмтэй тэмцэх тухай хууль гарсан ч үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцаа ажиллагаа, зохицуулалтууд төгс болж чадахгүй байна. Энэ нь терроризмтой тэмцэх ажлын үр нөлөөг бууруулах нэг хүчин зүйл болох тул цаашид террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, болзошгүй тохиолдолд хэрхэн хамтран ажиллах арга, хэлбэр, арга зүйг боловсруулж, эрх зүйн зохицуулалтандаа нарийвчлан тусгах шаардлага бий болсоныг харуулж байна.

Учир нь 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 12.1.1. “нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах”<sup>20</sup> гэж заасан боловч өнөөдрийг хүртэл террорист халдлага болсон тохиолдолд цагдаагийн алба хаагч ямар арга, хэлбэр, арга зүйгээр ажиллахыг зааварчилсан үйл ажиллагааны журам гараагүй байна.

<sup>19</sup> <http://eagle.mn/r/26947>

<sup>20</sup> Төрийн мэдээлэл. 2017.№8



Хууль сахиулахуй

Террорист үйл ажиллагаа манай оронд болоогүй ч Монгол Улсаар дамжин өнгөрч буй гадаадын иргэдийн тоо сүүлийн жилүүдэд өссөн, олон шашны сүмүүд байгуулагдаж байгаа зэрэг нөхцөл байдалд анхаарал хандуулах шаардлага тулгарч байна.

2016 онд Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх иргэдэд 21305 визийн зөвшөөрөл, 14122 виз олгож, гадаадын болон өөрийн орны иргэдээс хувийн журмаар гадаадын иргэнийг урих хүсэлтийг хянан 67 улсын 436 иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгосон байна.<sup>21</sup>

Монголд 328 мөргөлийн сүм хийд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаагийн 191 нь бурхны шашны, 127 христын, 5 нь бахайн, 5 нь лалын шашны сүм хийдүүд байна.<sup>22</sup>

Кибер терроризмын тухай ойлголт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга зам, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын үүрэг оролцоо, тулгамдсан асуудал, тэсэрч дэлбэрэх зүйлийн аюултай тэмцэхэд Зэвсэгт хүчний оролцоо, терроризмын аюултай тэмцэж буй гадаадын зарим орны туршлага, сургамж, шинэ технологит терроризмын аюул, түүнээс сэргийлэх, хамгаалах арга замын талаар Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж томоохон хэмжээний судалгааны ажил хийсэн байдаг.

Тэрээр 2016 оны 09 дүгээр сард “Зууны мэдээ” сонинд “Терроризмтой тэмцэх асуудлыг бид олон удаа хурал цуглаан хийж ярьж байгаа. Терроризмтой тэмцэх тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд учраа олохгүй байна.

Тэмцэх арга, механизмаа боловсруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, хил, гаалийнхан гэх мэт энэ асуудалд хамааралтай төрийн бүх байгууллага, дэлхийн бүх террорист байгууллагын нэрсийн жагсаалттай, томоохон террористуудын төлөөллийн зурагтай, түүний гар хөл бологсдын ч зурагтай байх ёстой. Тэр лавлагаагаар хил нэвтрэх бүх хүмүүсийг хянаж шалгаж байх төвшинд хүрэх учиртай. Харамсалтай нь манайд тийм зохион байгуулалт алга”<sup>23</sup> хэмээн ярилцлага өгсөн байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд терроризмтой

тэмцэхэд мэдээлэлд суурилсан цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, хэрхэн гүйцэтгэх арга зүйн зааварчилсан журам боловсруулж гаргах, дадлагажуулах сургалтыг тогтмол явуулж байх, нөгөө талаараа иргэдийн терроризмыг үзэх сэтгэлгээний хандлагыг өөрчилж, иргэд-цагдаагийн хамтын ажиллагааны үндэс суурийг бүрдүүлж чадвал терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэх нэг үндсэн нөхцөл бүрдэнэ.

### Санал

Цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс болон дээрх дурдагдсан дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд тусгайлан Терроризмтой тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам боловсруулж, террорист халдлага болсон бүс, нутаг дэвсгэрт цагдаагийн байгууллага, алба хаагчийн гүйцэтгэх үүрэг, хорио цээрийн дэглэм сахиулах, сөрөг тусгай ажиллагаа явуулах арга, хэлбэрийг нарийвчлан тусган оруулж өгөх;

2. Цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд харилцан, хамтран ажиллах тусгай чиг үүргийн байгууллагуудын үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж, Терроризмтой тэмцэх тухай хуульд тусгаж өгөх;

3. Иргэд, олон нийтийн “терроризм”-ыг үзэх сэтгэлгээний хандлагыг өөрчлөх танин мэдэхүйн сургалтын тогтолцооны бүрдэл хэсгийг бий болгож, олон нийтийн цахим сүлжээг ашиглан сургалт явуулах;

4. Терроризмтой тэмцэх цагдаагийн нийт алба хаагчийн үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг тусгасан гарын авлагыг боловсруулан сургалт явуулж, алба хаагчдыг чадваржуулах арга хэмжээ авах;

5. Терроризмтой тэмцэх, түүнээс аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлийн төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

<sup>21</sup> Гадаадын иргэн, харъяатын газрын 2016 оны тайлангаас хэсэгчилэн авав. <http://immigration.gov.mn/5635/>

<sup>22</sup> [https://mongolia.usembassy.gov/uploads/images/55oBdmm-685Mpc\\_tlqn1lw/Shashin.pdf](https://mongolia.usembassy.gov/uploads/images/55oBdmm-685Mpc_tlqn1lw/Shashin.pdf)



**Эх сурвалжийн жагсаалт****Хууль тогтоомж:**

1. Галт зэвсгийн тухай хууль.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.
3. Цагдаагийн албаны тухай хууль.
4. Терроризмтой тэмцэх тухай хууль.
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль.

**Тушаал, заавар, журам**

1. Ерөнхий сайдын 2004 оны 12 дугаар сарын 147 тоот захирамж.

**Ном, сурах бичиг, гарын авлага:**

1. Ц.Дашзэвэг, Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ., 2004.
2. Ч.Баатар, Ч.Алтангэрэл. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхноо хамгаалах нь. УБ., 2006.
3. "Терроризмын эсрэг". Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2003.
4. "Олон улсын терроризм ба аюулгүй байдал". ЭШБХ-ийн эмхтгэл. УБ., 2015.

**Сэтгүүл, эмхтгэл:**

1. Төрийн мэдээлэл. 2002. №3
2. Төрийн мэдээлэл. 2004. №19
3. Төрийн мэдээлэл. 2013. №24
4. Төрийн мэдээлэл. 2013. №29
5. Төрийн мэдээлэл. 2017. №8

**Цахим эх сурвалж:**

1. <http://www.legalinfo.mn/law/details/6691?lawid=6691>
2. <http://www.legalinfo.mn/law/details/3766?lawid=3766>
3. <http://eagle.mn/r/26947>
4. <http://immigration.gov.mn/5635/>
5. [https://mongolia.usembassy.gov/uploads/images/55oBdmn68SMpc\\_lmqn1lw/Shashin.pdf](https://mongolia.usembassy.gov/uploads/images/55oBdmn68SMpc_lmqn1lw/Shashin.pdf)
6. <http://news.gogo.mn/r/193347>